



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2022.08.30 № ЦМ-7/113 .

танай 2022.08.09 -ны № 212 -т

Г “ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ ББСБ” ХХК-Д Г

“Есөн шижир инвест ББСБ” ХХК-ийн Улаанбаатар хот, Баянзүрх дүүргийн салбарын захирлыг өөрчлөх хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянаж үзэхэд салбарын захирлаар томилохоор ирүүлсэн нь Цээлэйнамсаны Мөнхмандах нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа тул салбарын захирал Д.Найманцагааныг өөрчилж, Хорооны холбогдох бүртгэлд бүртгэсэн болно.

Салбарын захирал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгээ хийлгэж, холбогдох баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг мэдэгдье.

